



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны гишүүдийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4, 2.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллаж байсан тус яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт нар нь албан тушаалаас түр чөлөөлөгдсөнтэй холбогдуулан яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Батбаяр, Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын Анагаах ухааны инноваци, технологийн хэлтсийн шинжээч Д.Ганзориг нарыг дэд хорооны гишүүдээр томилсугай.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Б.Батбаяр, Д.Ганзориг нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт даалгасугай.

ДАРГА



Д.ОЧИРБАТ